



Байгалийн баялаг гэгчээр хvн торолхтон тэжээгдээд хэдэн зууныг vдэж байна. Дэлхий дээр байгалийнхаа баялгийн vр шимийг хvртээд эдийн засаг нь тогтворжоод, иргэд нь хоосон хонохгvй амьдарч байгаа улс орон нилээдгvй. Манайх бол байгалийнхаа баялгийг ашиглаж эхэлж байгаа ч эдийн засгийн эргэлтэнд оруулж амжаагvй орон. Байгалийн баялгаа ашиглаад багагvй хугацаа онгорч байгаа ч уул уурхай дагасан эдийн засаг, нийгмийн хогжил оноодор манай оронд орхигдсон гэхэд хилсдэхгvй байх. Бид гуравхан саяулаа. Гуравхан сая хvнийг тэжээгээд аваад явчих баялаг нь хангалттай л гэдэг. Гэвч уул уурхайн хогжил монгол оронд зов голдиролоороо явж байна уу гэвэл vгvй. Ард тvмнээсээ нуусан, хаалттай гэрээнvвдийг байгуулсаар... Үр огоожийг нь хvртэнэ хэмээн горьдсоор одий хvрлээ. Байгалийн баялгийг олборлож байгаа бол нохон сэргээнэ гэдэг хамгийн гол ажил байдаг. Баялгийг дагах уулыг тал, усыг шалбааг болгох их аян эх орны дорвон зvг найман зовхист орнож байна.

Монгол орны газрын доорх баялгийг дагасан шунал, хэн нэгний холжих хvсэл сонирхол хязгааргvй их юм шиг ээ. Энд алт гарч, тэнд тийм баялагтай гэнэ гэх сургаар оноох бидний нэрлэж заншсанаар нутаг нутгийн "нинжа" нар хурдан холгийн тоосоо манарган зорьцгооно. Замдаа тааралдсан болгоноос "Энvвхэнд алт гарсан гэнэ. Хаана юм" гээд хэнэг ч vгvй сураглана. Ай даа хvний шунал, холжих хvсэл гэж аугаа их юмаа даа. Газрын доорх баялгаар амьдраад сурчихсан хvн хэзээ ч оор ажил хийж чаддаггvй. "Чулууны амт"-нд орсон хэн ч буцдаггvй юм даа" гэж олон жил алт олборлосон нэгэн хvнээс сонсч байсан юм.

Байгалийн баялагаар баян Монгол орон минь хоосон гуу жалганууд, эрдэс баялгийг нь ухаад авччихсан уурхайн хаягдлууд нь газар сайгвй хоорхийлолтэй двр дврслэл хэдийнээ бий болжээ. Онгорсон он жилүүдэд бидэнд уул уурхайн салбар үр огоожоо огсон ч алтыг нь аваад авдрыг нь сүйдлээд орхисон уул толгод, газар нутаг Монголоор дүүрэн. Уул уурхайн вйл ажиллагаанаас үр шимээ хүртээд, нохон сэргээлттэй нь хослуулаад явбал унаган байгаль биш юмаа гэхэд ухаж сэндийчсэн, гуу жалга үүсэхгвйсэн. Манайд уул уурхайн нохон сэргээлт туйлын хангалтгвй байгаа. Тусгай хамгаалалттай газар нутагтаа хүртэл нохон сэргээлт хийлгэх нэрийдлээр ашигт малтмалыг нь олборлуулж байна. Ашигт малтмал олборлогчид гэхээр л “нинжа” нараар тосоолж, нохон сэргээлтийг зовхон ухсан нүхээ булаад, дээр нь цэцэг но-гоо тарьснаар хязгаарлаж болохгвй. Ирээдвйн амьдралаа уул уурхай, ашигт малтмалдаа даатгачихаад байгаа бид холоо харж сэтгэх цаг нэгэн болжээ.

А

Ашигт малтмалын ор-дыг тогтцынх нь хувьд гурав ангилдаг юм байна. Хүдрийн биетийн ашигтай давхарга нь газрын гадаргуутай параллель тогтоцтой байвал хэвтээ уналт-тай орд, бага зэргийн на-луугаар газрын гүн рүү шургасан бол налуу уналттай, огцом бол босоо уналттай орд гэж ялгагдаг байна. Уул уур-хайн ашиглалтын тех-но-логи, вйл явц, нохон сэргээлт эд-гээрээс хамаараад оор оор байдаг байна. Оноодор манай оронд мордогдож буй ихэнх баримт бичигт зааснаар уул уурхайн компаниудаас “Эвдэрсэн газраа булж хэвгийжүүлээд, дээрээс нь ургамал ногоо тарь” гэсэн агуулгатай зүйл л шаарддаг.

Нэг тэрбум тогрогийн олборлолт явуулсан уу?

Цэцэг сумын нутагт орших Мянган угалзатын нурууг 2002 онд УИХ-ын 39 дүгээр тогтоолоор тусгай хамгаалалтанд авсан бөгөөд 1960-1970 онд гянтболд /вольфрам/-ын орд илэрч судлагдаж албан ёсоор олборлолт хийгдэлгвй хамгаалалтанд авчээ. Гэвч иргэд сүүлийн хэдэн жилийн турш хууль бусаар вольфрам олборлож, тухайн газар нутагт ихээхэн хэмжээний хохирол учруулсан байдаг. Мянган угалзатын нурууны БЦГ-ын Цагаан эрэг хэмээх газарт иргэд 2000 оноос хойш хууль бусаар гянт болд олборлож байгаа бөгөөд зовхон манай аймгийн бус, Говь-Алтай, Завхан, Увс, Сэлэнгэ, Дархан, Баянхонгор гэх мэт аймгуудын “нинжа” нар ч ирдэг байна.

Нинжа нарын бусармаг, шунахай явдал ч Алтай, Цэцэг сумдыг тойроогүйгээр үл барам Цэцэг суманд 13 орчим га талбай сүйдсэн, нохон сэргээлт хийх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байдаг. Вольфрам буюу гянтболд нь дэлхийн зах зээлд маш ондор үнээр борлогддог богоод манай орны хэд хэдэн газарт нооц илэрсэн байдаг байна. Тухайлбал, Тов аймгийн Эрдэнэ Баяндавааны гянтболд, цагаантугалгын орд Баянчандмань суманд, Баян-Олгий аймгийн Ногоон нуур сумын Улаан-Уулын орд, Цэцэг сумын Цагаан эрэг гэх газруудад орд.

Вольфрамын ган хатуулаг ондортэй, бат бэх, хялбар хайлдаггүй, оороо оорийгоо ширгээдэг, хвчилдтэсвэртэй. Вольфрамын нэгдлүүдийг химийн урвалд будагч болгож, ондор чанартай бензин вйлдвэрлэхэд катализатор болгож хэрэглэдэг гэнэ. Гянтболдоор хийсэн сэлэм маш сайн хаттай, бат бох байдаг гэнэ. Учир нь гянтболд ондор хэмийн халууныг тэсвэрлэж чаддаг тодийгүй хамгийн хvнд металлд тооцогддог байна. Атомын зэвсэг, сансрын техник, чийдэнгийн гол зэрэг амьдрал ахуйд хэрэгцээтэй зүйлс хийдэг тодийгүй, зэр зэвсэг хийхэд оргон ашигладаг.

Цэцэг сумын иргэдийн огч буй мэдээллээр “Ашид Алтай Майнинг” ХХК-ны ард А БНХАУ-ы гурван иргэн байдаг гэх. Оноодрийн байдлаар 60-70 тонн вольфрам олборлоод байгаа юм. Оноодор зах зээлд чулуутай вольфрам нэг кг нь 12 000 тогрог, цэвэр нь 24 000-28 000 тогрогийн ханштай байна. Энэ нь “Ашид Алтай Майнинг” ХХК нэг тэрбум гаруй тогрогийн вольфрам олборлосон тооцоо гарч байна. “Ашид Алтай Майнинг” ХХК нь голын голидролыг оорчлон, шуудуу татаж вольфрам угааж Усны тухай хуулийг зорчиж байна.

“Ашид Алтай Майнинг” ХХК-ийхныг дураараа дургих боломжийг аймгийн ИТХ баталгаажуулж огсон гэж нутгийн иргэд хэлж байна. Тодруулбал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 07-р сарын 03-ны одрийн 82 дугаар тогтоолоор байгалийн давагдашгүй хвчин зүйл, хвний буруутай вйл ажиллагааны улмаас эвдэрч, доройтсон, унаган торхоо алдсан газруудад нохон сэргээлт хийх зорилгоор “Хондогдсон газарт нохон сэргээлт хийхэд хяналт тавих журам”-ыг баталжээ. Энэ нь А журам нь эвдэрч сүйдсэн газар нутагт техникийн болон биологийн нохон сэргээлт хийх мэргэжлийн байгууллага сонгон шалгаруулах эсвэл нохон сэргээлт хийх туршлагатай, тусгай зовшооролтэй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан нохон сэргээлт хийх вйл ажиллагаанд хяналт тавих, нохон сэргээх талбайн хвлээн авахыг журмын зорилго гэж тодорхойлжээ. Мон журамд нохон сэргээх хоронгийн эх үүсвэр нь улсын тосов, орон нутгийн тосов, олон улсын байгууллагын тосол, хотолбор, хандив тусламжаар санхүүжихийн зэрэгцээ тухайн газар дээрх хаягдал шлам, отволи, овоолгыг дахин угаах замаар нохон сэргээлтийн ажлаа санхүүжүүлж болно гэж заажээ.

Түүнчлэн нохон сэргээлт хийх аж ахуй нэгж нь тусгай зовшооролтэй, ажиллах хvч, тоног тохооромжоор хангагдсан, татвар нийгмийн даатгал, банкны хугацаа хэтэрсэн оргvй, хуулийн этгээд байх тухай шаарлагыг тусгаж огчээ.

2015 оны 07-р сарын 3-нд нэхvv журмыг баталсны дараахан буюу 07-р сарын 09-нд “Ашид Алтай Майнинг” ХХК-д Мянган угалзатын нурууны байгалийн цогцолбор газарт хамаарах Цагаан эрэгт нохон сэргээлт хийх зовшоорлийг олгосон байгаа юм. Журам батлагдаад долоо ч хоноогvй нохон сэргээлт явуулах зовшоорол олгосон нь хэний эрх ашигт нийцсэн вйлдэл вэ? Хондогдсон газраа нохон сэргээх нь чухал ч хэд хэдэн хууль зорчиж байгааг сануулан нутгийн 30 гаруй иргэн сумын ИТХ-даа шаардлага хvргvvлжээ. Уг шаардлагад “...Гэрээ нь: Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, аймгийн ИТХ-ын 82 дугаар тогтоол”-ыг зорчиж, нохон сэргээлт хийх нэрийдлээр олборлолт явуулж байгаа тул таслан зогсоохыг шаардаж буйгаа илэрхийлжээ.

Мон БОАЖГ-аас аймгийн ЗДТГ-ын ХБХ-т ирvvлсэн албан бичигтээ “...Ашид алтай майнинг ХХК-ийн вйл ажиллагаанд хяналт хийхэд Уул уурхайн вйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нохон сэргээлт хийх аргачлал, аймгийн ИТХ-ын 22.2.1, 22.8 дугаар тогтоолын хавсралт журам, Усны тухай хуулийн 3 дугаар бvлгийн 22.2.1, 22.8 дугаар зvйлvvдийг зорчсон нь тогтоогдсон тул зохих шийдвэрийг гаргаж огно vv” гэжээ.

Оноодор энэ талаар арга хэмжээ авсан торийн байгууллага, албан тушаалтан нэг ч алга. Үнэхээр техникийн болон биологийн нохон сэргээлтийг vр дvнтэйгээр хийвэл нутгийн иргэдийн зvгээс эсэргvvцэх шаардлагагvй. Гэтэл голын голдиролоос ус татаж, хууль бусаар ашигт малтмал олборлосноор нохон сэргээлт явуулж байгааг тэд эсэргvvцэж байгаа юм. Дараагийн дугаарт Цагаан эрэгт болж буй вйл явдлын талаарх мэдээллийг vргэлжлvvлэн хvргэх болно.

Г. Энхжаргал